



2013 оны 3 сарын 15  
(11&12-р хэвлэл)

# МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ Э-СОНИН

Монголын хөрөнгийн биржийн хамт олон “Оны Шилдэг Шинэчлэл” шагналыг авлаа

Bloomberg TV Mongolia нь олон нийтэд хүрээд жил хүрэхгүй хугацаанд бизнес, тэр тусмаа санхүүгийн салбарын мэргэжилтнүүдийн шимтэн үздэг суваг болоод байгаа билээ. Шинэлэг, шинэ шийдэл бүхий олон сонирхолтой нэвтрүүлэг, ярилцлага, мэдээ, мэдээллийн булангуудаараа олон нийтэд танигдаад буй тус хамт олон энэ удаа “Bloomberg Awards 2012” нэрэн доор “Шилдэг хэлцэл”, “Шилдэг төсөл”, “Шилдэг шинэчлэл”, “Шилдэг анхдагч бонд” болон “Оны шилдэг эдийн засагч” номинацуудаар шилдгийн шилдгийг 2013 оны 3-р сарын 5-ны өдөр тодруулан ёслол төгөлдөр болж өндөрлөсөн. Энэхүү шагнал гардуулах үйл ажиллагааны үеэр Монголын хөрөнгийн биржийн дотоодын хөрөнгийн зах зээлд нэвтрүүлэн нутагшуулсан Милленниум АйТи арилжаа, төлбөр тооцоо, хяналт, хадгаламжийн цогц систем нь оны шилдэг шинэчлэлийн ажил хэмээн дүгнэгдэж, “Best Innovation” буюу “Шилдэг шинэчлэл” шагналыг Монголын хөрөнгийн биржийн хамт олон авлаа.

## Мэдээний тойм:

- Монголын хөрөнгийн биржийн хамт олон оны шилдэг шинэчлэл шагналыг авлаа
- “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийн тухай
- Сүүлийн 1 сарын арилжааны мэдээ
- Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 156 дугаар тогтоолын өөрчлөлт
- Хувьцаат компаниудтай холбоотой мэдээлэл
- Ногдол ашиг тараалтын судалгаа

## Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн хурлын шийдвэрийн тухай

“Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит хурал 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдөр Монголын хөрөнгийн биржийн байранд болж дараах шийдвэрүүдийг гаргалаа. Үүнд:

1. **Хувьцааны арилжааны шимтгэлийг буурууллаа.** Монголын хөрөнгийн бирж нь хувьцааны арилжааны үнийн дүнгээс хамааруулан 5 шатлалаар шимтгэл тооцон авдаг бөгөөд зах зээлд оролцогчдыг дэмжих зорилгоор хувьцааны арилжаанаас авч буй шимтгэлийн эхний хоёр шатлалыг буюу 100 сая хүртэл төгрөгийн үнийн дүнтэй арилжаанаас авах шимтгэлийг “0.5%” байсныг “0.4%” болгон, 100 саяас 1 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй арилжаанаас авах шимтгэлийг “0.4%” байсныг “0.38%” болгон тус

тус буурууллаа.

№	Арилжааны үнийн дүн	Нэг хэлцлээс авах шимтгэл	Өөрчлөлт
1	100 сая хүртэл төгрөг	0.5%	0.4%
2	100 сая-1 тэрбум төгрөг	0.4%	0.38%
3	1-10 тэрбум төгрөг	0.3%	0.3%
4	10-30 тэрбум төгрөг	0.2%	0.2%
5	30 тэрбум төгрөгөөс дээш	0.15%	0.15%

Энэхүү өөрчлөлтийг 2013 оны 3 дугаар сарын 11-ний өдрөөс мөрдөж эхлээд байна.

2. **“Блюскай секьюритиз” ХК болон “Хүннү Эмпайр” ХХК-ийг Монголын хөрөнгийн биржийн гишүүнээр элсүүлээ.** Ингэснээр Монголын хөрөнгийн биржийн гишүүн компанийн тоо 82-т хүрлээ.

## TOP-20 индексийн үзүүлэлт



2013 оны 2 дугаар сарын 15-наас 2013 оны 3 дугаар сарын 15-ны хооронд нийт 20 удаагийн арилжаа явагдаж, 82 компанийн 842.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий 1.8 сая ширхэг хувьцаа арилжсан байна.

Тус хугацаанд хамгийн идэвхтэй арилжигдсан компани нь “Монголиа Девелопмент Ресорсес” ХК /255.0 сая.төг/, “Хай Би Ойл” ХК /162.3 сая.төг/ “АПУ” ХК /64.8 сая.төг/ байсан байна.

## Үнэт цаасны арилжааны мэдээ

### Хувьцааны арилжаа

Арилжаа явагдсан өдөр	20
Арилжигдсан ширхэг	1.8 сая
Арилжигдсан дүн	842.9 сая төгрөг
Арилжигдсан компанийн тоо	82
Өдрийн дундаж	42.1 сая төгрөг

### Хамгийн их өсөлттэй:

Материалимпекс /MIE/	+72.73%
Монгол шевро /MVO/	+43.56%
Бишрэлт индустриал /HNC/	+39.78%

### бууралттай:

Баян-алдар /VIK/	-60.10%
Зоос гоёл /ZOO/	-39.29%
Монгол савхи /UYN/	-26.69%

### Зах зээлийн үнэлгээ:

1,633.1 тэрбум төгрөг
1.16 тэрбум ам.доллар

### TOP-20 индексийн өөрчлөлт:

16,117.34 / -0.4%
-------------------



## Хувьцаат компаниудын хурлын тов

### Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолд өөрчлөлт орлоо

Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хуралдаанаас дараах шийдвэрийг гаргажээ:

Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны “Үнэт цаасны зах зээлд оролцогч тусгай зөвшөөрөл бүхий этгээдээс төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 156 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулж, Санхүүгийн зохицуулах хорооны брокер дилерийн компаниудын хувьцааны арилжааны шимтгэлээс авах зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг “0.13” хувь байсныг “0.04” хувь болгон бууруулсан байна.

Энэхүү өөрчлөлтийг 2013 оны 3 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн мөрдөж байгаа аж.

Хувьцаат компаниудын “Хувь нийлүүлэгчдийн хурлын тов”-ын дэлгэрэнгүйг Монголын хөрөнгийн биржийн албан ёсны цахим хуудас руу нэвтрэн **КОМПАНИЙН БҮРТГЭЛ** цэс рүү орж **ХУРЛЫН ТОВ** хэсгээс үзнэ үү. [www.mse.mn/conf/list](http://www.mse.mn/conf/list)

### 134 хувьцаат компани 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ирүүлээд байна

2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудаас 180 хувьцаат компани 2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа ирүүлээд байна. Тайланг Монголын хөрөнгийн биржийн албан ёсны цахим хуудас руу нэвтрэн **КОМПАНИЙН БҮРТГЭЛ** цэс рүү орж **ХК-ИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН** хэсгээс үзнэ үү.

### Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн хувьцаат компаниуд

2013 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар Монголын хөрөнгийн биржид 15 хувьцаат компани нийт 367,898,152 ширхэг хувьцаанд 8,818,351,503 төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тухай ТУЗ-ийн шийдвэрээ ирүүлээд байна.

Д/д	КОМПАНИЙН НЭР	ТООН КОД	ҮСГЭН КОД	САЛБАР	БАЙРШИЛ	НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ/ТӨГ/	НИЙТ ХУВЬЦААНЫ ТОО ШИРХЭГ	НОГДОЛ АШГИЙН НИЙТ ДҮН /ТӨГ/	ТАРААХ ХЭЛБЭР	БҮРТГЭЛИЙН ӨДӨР
1	Говь	354	GOV	В	УБ	125	7,801,125	975,140,625	ХК, ҮЦТТТХТ	2013-03-04
2	Гермес центр	528	HRM	Е	УБ	5.09	78,543,001	399,783,875	ҮЦТТТХТ	2013-03-03
3	Шарын гол	309	SHG	А	ДА	50	10,231,389	511,569,450	ҮЦТТТХТ	2013-03-04
4	АПУ	90	APU	В	УБ	70	74,287,700	5,200,139,000	ҮЦТТТХТ	2013-03-11
5	Бидисек	522	BDS	Е	УБ	60	11,000,000	660,000,000	ҮЦТТТХТ	2013-03-04
6	Тахь-ко	44	ТАН	В	УБ	56	1,189,983	66,639,048	ҮЦТТТХТ	2013-03-14
7	Баянтээг	445	BTG	А	ӨХ	100	252,608	25,260,800	ҮЦТТТХТ	2013-03-07
8	Улаанбаатар БҮК	195	BUC	Д	УБ	137	1,128,275	154,573,675	ҮЦТТТХТ	2013-03-11
9	Тулга	5	TLG	Е	УБ	60	131,620	7,897,200	ҮЦТТТХТ	2013-03-10
10	Тээвэр дархан	217	ТЕЕ	Д	ДА	400	163,349	65,339,600	ҮЦТТТХТ	2013-03-30
11	Монгол алт	68	ERC	А	ДА	150	265,852	39,877,800	ҮЦТТТХТ	2013-03-30
12	Ремикон	530	RMC	В	УБ	1.27	78,679,464	100,000,000	ҮЦТТТХТ	2013-03-15
13	Махимпекс	208	MMX	В	УБ	80	3,800,721	304,057,680	ХК	2013-03-25
14	Баянгол ЗБ	13	BNG	Е	УБ	350	423,065	148,072,750	ҮЦТТТХТ, ХК	2013-03-17
15	Женко тур бюро	521	JTB	Е	УБ	1.6	100,000,000	160,000,000	ҮЦТТТХТ, ХК	2013-03-21
<b>НИЙТ</b>							<b>367,898,152</b>	<b>8,818,351,503</b>	-	

\* БАЙРШИЛ

УБ—Улаанбаатар

ДА—Дархан

ӨХ- Өвөрхангай

\*САЛБАР

А - Уул уурхай

В - Аж үйлдвэр

С - Хөдөө аж ахуй

Д - Барилга тээвэр

Е - Худалдаа үйлчилгээ